

ГАДААД АЖИЛТНЫГ МОНГОЛ УЛСАД ИРСНИЙ ДАРАА ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр урьдчилсан зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагын гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Гадаад ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулахад Эрүүл мэндийн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэ журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах

2.1 Аж ахуйн нэгж, байгууллага тухайн гадаад иргэнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүсэхээс өмнө эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулна.

2.2 Эрүүл мэндийн байгууллага гадаад иргэнд хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолын халдвар /ХДХВ/ДОХ/, тэмбүү, элэгний В, С вирусийн халдвар илрүүлэх болон уушгины сүрьеэгийн үзлэг, шинжилгээг хийж үзлэгийн нэгдсэн дүгнэлтийг холбогдох журмын дагуу гаргана.

2.3 Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолын халдварын тохиолдлын мэдээлэл нь Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулиар зохицуулагдана.

2.4 Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүгнэлтийг 14 хоногийн дотор аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.5 Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан дүгнэлт болон Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 24.1 дэх хэсэгт заасан бусад баримт бичигт үндэслэн хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоно.

2.6 Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр энэ журмын 2.2 дахь хэсэгт заасан өвчин илэрч, эрүүл мэндээр тэнцээгүй гадаад иргэний мэдээллийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

2.7 Гадаад ажилтны нэг жилийн хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусч, сунгах тохиолдолд энэ журмын 2.2 дахь хэсэгт заасан үзлэг, шинжилгээнд дахин хамрагдана.

2.8 Гадаад ажилтан 6 ба түүнээс дээш сараар хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд ХДХВ/ДОХ-ын халдвар илрүүлэх шинжилгээнд 6 сар тутамд хамрагдана.

Гурав. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулахад тавигдах шаардлага

3.1 Эрүүл мэндийн байгууллага энэ журмын 2.2 дахь хэсэгт заасан эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд гадаад иргэнийг холбогдох журмын дагуу хамруулна.

3.2 Гадаад иргэнийг үзлэг, шинжилгээнд хамруулахдаа үзлэг, шинжилгээний байршлыг харилцан тохиролцож, халдвар хамгааллын болон бусад дүрэм, журмыг баримтлан, аж ахуйн нэгж, байгууллагад хүндрэл учруулахгүйгээр зохион байгуулна.

3.3 Үзлэг, шинжилгээний хариуг энэ журмын хавсралтаар батлагдсан маягт дээр гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

3.4 Үзлэг, шинжилгээг мэдрэг, өвөрмөц чанар өндөртэй оношлуураар хийж, шинжилгээний хариу эргэлзээтэй тохиолдолд дараагийн шатлалд холбогдох журмын дагуу илгээж, хариуг баталгаажуулна.

3.5 Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээтэй холбоотой бичиг баримтыг Архивын тухай хуулийн дагуу хадгална.

Дөрөв. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр, хариуцлага

4.1 Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж байгаа гадаад ажилтны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд шаардагдах зардлын хэмжээнд санхүүгийн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон жишиг үнийг мөрдлөг болгоно.

4.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд шаардагдах төлбөрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

4.3 Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.

4.4 Энэ журмыг зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол Иргэний хуульд заасны дагуу буруутай этгээд уг хохирлыг нөхөн төлнө.



Хөдөлмөрийн сайдын
оны /19/08/2020/ тоот тушаалын
Хөрдугаар хавсралт

Гадаадаас Монгол улсад ажиллаж буй иргэдийн
эрүүл мэндийн үзлэгийн маягт

- A. Урьдчилсан үзлэг хийсэн эрүүл мэндийн байгууллагын нэр
- B. Гадаадаас ажиллах хүч авч буй байгууллагын нэр
- B. Иргэний овог нэр: Нас Хүйс
- Г. Иргэний харъяалал
- Д. Паспортын дугаар
- E. Шинжилгээний дүн:

№	Үзүүлэлт	Хариу
1	HIV	
2	Сүрьеэ	
3	TPHA	
4	HBs антиген	
5	HCV	
	Дүгнэлт	

Эмчилгээ эрхэлсэн захирал :

Тамга Эмч:

Лабораторийн эмч:

Лаборант:

.....он.....сар.....өдөр